

Орос хэлний толь бичгүүдэд орсон монгол үгс

Балжсинам Н.  
/МУИС/

Монгол хэлшинжлэлд гол төлөв монгол хэлэнд орсон харь үгийн судалгаа нэлээд байгаа хэдий ч монгол хэлнээс гадаад хэлэнд орсон үгсийн талаар хийсэн судалгааны ажил харьцангуй бага юм. Үүнийг нэгд, монгол хэлийг тоож хэрэглэх улс орон байхгүй мэтээр ойлгож ирсэн; хоёрт, монгол хэлний үгийг гадаад хэлний толь бичиг болон судалгааны ном зохиолоос ялгаж танихад бэрхшээлтэй болсон; гуравд, европын хэлний толь бичгүүдэд монгол үг болгоныг түрэг үг хэмээн тэмдэглэн тайлбарлаж ирсэн; дөрөвд, энэ талын судалгааны арга зүй дутагдалтай байгаа; тавд, монгол хэлний бүх үгийг дэслэж бүртгэсэн монгол хэлний их тайлбар толь хараахан гараагүй... зэрэг шалтгаантай холбож тайлбарлахаас аргагүй юм.

Орчин үед монгол хэлний ямар ямар үг дэлхийн аль хэлэнд орсон, хэлбэр нь хэр зэрэг өөрчлөгдсөн, утга нь орчин цагийн монгол хэлний тухайн үгийн утгатай таарч байгаа эсэх, тэдгээр үгсийн тархац ямар байгаа, одоо энэ үг төрөл хэлнүүдийн алинд нь илүү хэрэглээтэй байгаа... зэргийг судалгааны үндсэн дээр тогтоох нь чухал байна. Ингэхдээ монгол оронтой олон зууны турш түүх, соёлын олон талаар холбоотой явж ирсэн дэлхийн том гүрнүүд болох орос, хятад хоёр ард түмний хэлэнд монгол хэлнээс орсон үгийг бүртгэж, түүнийг гаралзүй, түүхэн үүднээс нь судалж үзэх явдал чухал юм.

Хэдийгээр хэв шинжийн хувьд монгол, орос хоёр хэл өөр өөр ч гэсэн орчин цагийн монгол хэлэнд хэрэглээ нь хэвээр байгаа олон тооны үг орос хэлэнд орж идээшин хэрэглэгдэж байна. Эхний ээлжинд эдгээр үгсийг толь бичгийн хэрэглэгдэхүүнд тулгуурлан бүртгэж, зохих тайлбарыг хийх нь зүйтэй юм. Орос хэлний тулгуур толь бичгүүдийн нэг, анхны хэвлэл нь 1863-1866 онуудад гарсан В.Далийн <<Орос хэлний жинхэнэ их тайлбар толь>>-д монгол хэлний өргөн хэрэглээний 100 гаруй үг орсон байна. Зарим үгийг орос хэлний нийтэд түгээмэл толь бичгүүдээс нөхөж оруулав. Эдгээр монгол үгсийн ихэнхи нь орос хэлний бусад толь бичгүүдэд нэгэн адил тэмдэглэгдэн хэрэглэгдсээр иржээ.

В.Даль орос хэлэнд орсон харь үгийн талаар эхний үед нэлээд хатуу бодолтой байсан хэдий ч тэрээр тайлбар тольдоо гадаад хэлний үг оруулахаас татгалзаагүй юм. Энэ талаар тэмдэглэгээ болгож бичихдээ: <<Гадаад үгийг толь бичигт оруулахгүй

байснаар тэдгээрийн тоо цөөн болж багасахгүй, харин оновчтой хэлбэрээр тольд байрлуулж, тэдгээрийг онож орчуулбал хүмүүсийн санаанд хүрч, аяндаа гадаад үг хэрэглээнээс гарч, оронд нь орос үг хэрэглэгдсэнээр орос хэлийг цэвэр ариун байлгаж болох юм>> гэж үзэж байжээ. Ингэсний улмаас монгол хэлний эдгээр үг орос хэлэнд орж идээшин, зарим нь өргөн хэрэглээтэй болж чадсан байна. Одоо энэ үгс орос хэлний үгийн нэгэн адил орос хэлний зүйгээр дүрэмжин, орос хэлний үгийн ерөнхий хэлбэрийг олсон байна. Ихэнхи үг нь ярианы хэлээр дамжиж орсон учраас үгийн хэлбэр нэлээд өөрчлөгдсөн, танихад бэрхшээлтэй болсон байна.

Эдгээр үгсийн гарал, түүхэн хувьсал, утга зүйн талаар тодорхой хэрэглэгдэхүүнд тулгуурлан монгол үг эсэх талаар тодоруулга хийсэн болно.

Үгсийг орос хэлний зүйгээр хэрхэн хэлбэржүүлэн толь бичгүүдэд тэмдэглэн оруулсаныг үзүүлбэл;

**аймак** м. Даль I-7, **айран** м. Даль I-7, **аксакал** м. Даль I-8, **алтын** м. Даль I-12, **анжиган**, **анджиган** м. Даль I-17, **арак** м. Даль I-20, **арат** м. Ож. -20, **аргали** Даль I-21, **армак** м. Даль I-21, **аргасун**, **аргал** м. Даль I-21, **аркан** м. Даль I-22, **арса**, **арца** ж. Даль I-24, **арчул** м. Даль I-7, **аршан** м. Даль I-24, **арык** м. Уш., I-68, **аул** м. Даль I-29, **багана** ж. Даль I-35, **бадан** м. Даль I-36, **базар** м. Даль I-37, **бакша** м. Даль I-40, **балта** ж. Даль I-44, **бамбай** м. Даль I-44, **барс** м. Даль I-51, **батырь** м. Даль I-54-55, **бахадур** м. СЭС.-115, **богатырь** м. Даль I-7, **беркуть** м. Даль I-84, **богдыхан** м. Уш. - I-161, **булат** м. Даль I-140, **бурун** м. Даль I-144, **бурхан** м. Даль I-144, **ганза** ж. Даль I-344, **гичь** ж. Даль I-351, **гуджир** м. Даль I-405, **гунак**, **гуначик** м. Даль I-408, **гуран** м. Даль I-408, **гутулы** м. Даль I-411, **даба** ж. Даль I-412, **даган** м. Даль I-414, **дайга (тайга?)** ж. Даль I-414, **далай-лама** м. СРЯ, I-362, **даха** ж. Даль I-416, **дацан** м. Даль I-416, **дефтер** м. Даль I-434, **джида** ж. Даль I-434, **джейран** м. Даль I-434, **джут** м. СРЯ- I-396, **дунан** м. Даль I-501, **есаул**, м. Уш. - 837, **жирим**, **джижим** м. Даль I-542, **затуран** м. Даль I-653, **зерен** м. Даль I-680, **ирбис** м. СРЯ - I-635, **ирген**, **иргень** м. Даль II -47, **ишигенка** ж. Даль II-67, **казан** м. Даль II -1262, **капкан** м. Ушк. 1313, **карагана** ж. Даль IV-648, **Карадаг** СЭС.-543, **карандаш** м. Даль II-90, **караул** м. Даль II-91, **карий** м. **каурий** м. Даль II-98, **кулан** м. Даль II-215, **кураган**, **курагашек** м. Даль IV-569, **куцан** м. (монг.) Даль II-640, **лама** м. Даль II-98, **малахай** м. Даль II-292, **мангир** м. Даль II-296, **марал** м. Даль II-299, **махлай**, **махлан**, **махалай** м. Даль II-309, **мерен** м. Даль II-321, **обон** м. Даль II-610, **онгонный**, **онгоненый** **олень**, **лошадь** Даль II-673, **панты** мн. Даль III-316, **саадак** м. Даль IV-126, **саба** ж. Даль IV-126, **сарай** м. Ушк., IV-51, **Саратов** СЭС.-1170, **сарлук** м. Даль IV-139, **солонгой** м. Даль IV-267, **сундула** ж. Даль IV-361, **табарган** м. Даль IV-384, **табун** м. Даль IV-684, **таган** м. Даль IV-684, **тайга** ж. Ушк., IV-636, **тайлаган** м. Даль IV-386, **тайша** м. Даль IV-387, **талай тулай** м. Даль IV-388, **тамга** ж. Даль IV-390, **тарасун** м. Даль IV-391, **тарбаган** м. Даль IV-391, **Тарбагатай** СЭС.-1309, **тархан** м. Даль IV-391-392; **тек** м. Даль IV-396, **тойн** м. Даль IV-410, **толой**, **тулай**, **толуй** м. Даль IV-412, 413(монг. туула), **торлук** м. Даль IV-420, **тулун** м. Даль IV-442, **алагдай** м. Даль IV-446, **тек** м. (стар. Теке, козёл) Даль IV-396, **тыкен** м. Даль IV-447, **тымен** м. Даль IV-447, **укрюк** м. Даль IV-486, **улала(о)кать кого** Даль IV-487, **улар**, -а, м. ССРЯ XVII-530, **улачи** ж. Даль IV-487, **ямщина** ж. Уш. IV-1462, **улус** м. Даль IV-489, **улюля** ж. Даль IV-490, **ундак** м. Даль IV-498, **унина** ж. Даль IV-498, **уран** м. Даль IV-507, **ураса** ж. Даль IV-507, **ургуй** м. Даль IV-507, **урень** м. Даль IV-508, **хадак** м. Даль IV-541, **халзаний** Даль I-342, **халтарый конь** м. Даль IV-541, **халюный конь** м. Даль IV-541, **хан** м. Уш., IV-1132, **хандагай кандалай** м. Даль III-

150, **хорун** м. Даль IV-562, **хота** ж. Даль IV-562, **хотон** м. Даль IV-562, **хрида** Даль IV-565, **худук** м. кудук Даль IV-569, **хураган** м. Даль IV-569, **хурул** м. Даль IV-569, **хутулы** Даль IV-569, **чембур** м. СРЯ, IV - 661, **шара** ж. **Сиб. монг.** Даль IV-621, **яман** м. **яманиха** ж. , **ямануха** Даль IV-677, **ямщик** м. Даль IV-678.

Эдгээр үгсийг зүйлчилэн үзвэл;

1. Монголчуудын садан төрлийн холбоо хийгээд зон олны хуран цугларахын утга бүхүй нэр: **аймак, аул, улус, хота, хотон, хурул.**
2. Уламжлалт зарим идээ, ундааны нэр: **Айран, арак, затуран, тарасун, ундак, урень.**
3. Хүмүүсийн хэргэм зэрэг, ажил, мэргэжил хийгээд зарим нэгний нийтлэг бус ялгааг заасан нэр: **Аксакал, арат, бакша, батырь, бахадур, богатырь, есаул, караул, тайша, тархан, улачи, халзаний, хан, ямщик.**
4. Эрдэнэ, ган төмрийн нэр: **алтын, булат.**
5. Залуу төл малын нэр: **Анжиган, анджиган, бурун, гунак, гуначик, даган даганчик, дунан, инзаган, кураган, курагашек, хураган.**
6. Өвсөн тэжээлт ан амьтаны нэр: **Алагдай, аргали, гуран, джейран, зерен, кулан, марал, табарган, талай тулай, тарбаган, толой, тулай, тек (теке), хандагай кандалай.**
7. Мэрэгч жижиг махчин амьтаны нэр: **Солонгой**
8. Монголчууд эрт цагаас адгуулан, ашиг шимийг нь хүртэж ирсэн таван хошуун малын нэр: **Аргамак, ирген, иргень, куцан, мерен, сарлук, тек, тыкен, тымен.**
9. Түлээ, түлшний нэр: **Аргасун, аргал,**
10. Морь, малын тоног хэрэгсэлийн нэр: **Аркан, жирим, джирим, укрюк, чембур.**
11. Өвс ургамал, анхилуун үнэртний нэрс: **Арса, арца, бадан, бамбай, гичь, карагана, мангир, торлук, ургуй.**
12. Ус, ундарга, хужир мараатай холбоо бүхүй нэр: **Аршан, гуджир, худук.**
13. Ахуйн хэрэглээний эд зүйлсийн нэрс: **Арчул, ганза, ишигенка, казан, саба, таган, тамга, товар, тулун, шара.**
14. Гэр, орон хийгээд түүнийг бүрэлдүүлж буй зүйлийн нэр: **Багана, унина, ураса.**
15. Хувцас хунар, түүнийг хийх эд зүйлийн нэр: **Гутулы, даба, даха, малахай, махлай, махлан, махалай, хутулы.**
16. Зэр зэвсэгийн нэр: **Балта, бамбай, джида, саадак, капкан.**
17. Бурханы шашины санваартан-дээдэс, орон байр, эд зүйлийн нэр: **Богдыхан, бурхан, дацан, далай-лама, лама, тойн, хадак.**
18. Бөө мөргөлтэй холбоотой нэр: **Обон, онгонный, онгоненый, тайлаган.**
19. Араатан амьтаны нэр: **Барс, ирбис.**
20. Даль жигүүртэний нэр: **Беркуть, улар, улюля.**
21. Газрын гадарга, байгалийн бүсийн нэр: **Арык, дайга (тайга?), тайга.**
22. Бичгийн хэрэгсэлийн нэр: **Дефтер, карандаш.**
23. Байгалийн цаг зуурын бэрхшээлийн нэр: **Джут.**
24. Мал адгуусын зүсийг заасан үг: **Карий, каурыз, халтарый, халюный.**
25. Амьтаны гаралтай эмийн нэр: **Панты.**
26. Уриа, дуудлагын нэр: **уран.**
27. Аливаа зүйлийг агуулах орон савын нэр: **Амбар, анбар, сарай, хорун.**
28. Үйл, байдлыг заасан утгатай зарим үг: **Сундула, улала(о)коть.**
29. Хүний байр байдлыг заасан үг: **хрида.**

30. Малын гаралтай хоол хүнс, арьс үсээр хийсэн эд зүйлийн нэр: **яманиха, ямануха, Яманья даха.**

31. Уул нуруу, хот тосгоны нэр: **Карадаг, Саратов.**

Эдгээр үгсийн дотор харь хэлнээс монгол хэлэнд орж идээшсэн үг ч байна. Энд орсон үг тус бүрийг түрэг хэлтэй ард түмний түгээмэл хэрэглээтэй толь бичгүүд, монгол хэлний тайлбар толь, бусад толь бичгүүд болон судалгааны тулгуур ном зохиолуудыг эш болгон авч үзье.

В.Даль *аймаг* хэмээх үгийг тайлбарлахдаа - *монголчууд хийгээд тэдэнтэй адил овог аймгуудад: дээд өвөг нэгтэй нэгэн төрлийн отог, овог, үе, хүй нэгдэл.* Бид энэ үгийг *волость* - *хушуу, отог* хэмээн орчуулна гээд цааш нь хальмаг үндэстэнд бол боолчлогдсон ард олон хийгээд овог мөн тайж, ноёдын харьяат газар улмаар тэдний эзэмшил хүмүүсийг ийнхүү нэрлэнэ. Нэр үндэсээс *аймачный, аймаковый* гэсэн хоёр тэмдэг нэр үүснэ гэж тайлбарлав.

С.Ожегов аймаг гэдэг үгийг тайлбарлахдаа: Буриад-Монгол автономит улс, Уулын Алтайн автономит муж, БНМАУ-ын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэр гэв.

Д.Ушаковын хэмээн алдаршсан Орос хэлний тайлбар толь бичигт: аймаг нь [монгол. *ajmaq*] (офиц.) - Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж; Хальмагийн Автономит мужид овог отгийн нэг хэсэг, Ойрадын автономит муж болон Зөвлөлтийн Буриад-Монголын автономит улс зэргийн дүүргийг ийнхүү хэлнэ гэжээ.

Сүүлийн үеийн хэмээн нэрлэгдэх Орос хэлний 4 боть толь бичигт ЗСБН автономит Буриад улс болон Уулын Алтайн автономит мужид дүүргийг ийнхүү нэрлэнэ. БНМАУ-ын засаг захиргаа нутаг дэвсгэрийн үндсэн нэгж гэжээ.

Орос татар толь бичигт *аймак*, Орос хальмаг тольд *аамг*, Киргиз орос толь бичигт улс, орон, нутаг дэвсгэр хийгээд нэг аймгийн хүн амыг хэлнэ хэмээн тус тус бичжээ.

О.Ковалевскийн Монгол-орос-франц толь-д *аймак* - *аймау* хэмээгээд тусдаа, ангидаа, бөөнөөрөө, нэг доор байдгаараа нэг төрлийн, тусгайлан нэг доор болгосон зүйл гэжээ. Мөн *аймак* - народ, люди гэсэн утгатай гэж тэмдэглэв.

Оросын орчин цагийн утга зохиолын хэлний толь бичигт 1. ЗСАБуриад-Монгол Улс, Автономит Ойрад мужийн засаг захиргааны хуваарь ёсоор нутаг дэвсгэрийн нэгж; энэ нь тойрогтой тэнцүү. 2. түрэг, монгол үндэстэний төрөл угсаа, овог аймгийн нэр гэжээ. Энэ үг дундад үеийн орос хэлэнд XVII зууны үед *аймак* гэсэн хэлбэрээр, 1835 оноос аймак хэлбэрээр толь бичгийн хэрэглэгдэхүүн болж орсон хэмээн тэмдэглэсэн байна.

Монгол бичгийн болон ярианы хэлэнд *аймаг* хэмээн бичиж, ярьдаг байтал орос хэлний толь бичигт *аймак* хэмээн орсоны учир гэвэл монгол хэлний -г гийгүүлэгчээр төгссөн нэрийг орос хэлэнд -к гийгүүлэгчээр төгсгөн хэлж, бичдэг, жишээлбэл, *Алтанбулаг* хотыг *Алтанбулак*, *ариг* гэхийг *арык* хэмээн тус тус оросоор ярьж, бичнэ. Харин орос хэлний -к гийгүүлэгчээр төгссөн үгийг монгол хэлэнд -г гийгүүлэгчээр төгсгөн ярьж, бичих нь бий, жишээлбэл, *ток* гэдгийг *тог*, *Владивосток* хотын нэрийг *Владивостог*, *практика* гэдгийг *прагтик* хэмээн бичиж, ярьдаг учраас энэ *аймаг* гэдэг үг *аймак* хэмээн бичигдэх болсон байна.

Энэ нэрийн авианы хувьслыг академич Д.Төмөртоогоо тэмдэглэхдээ: өвөг монгол хэлэнд *ayimay*, эртний монгол хэлэнд *ayi:may*, дундат үеийн монгол хэлэнд *ayi:may*, орчин үеийн монгол хэлэнд *aimag* хэмээн тус тус бичиж ирсэн гэжээ.

Орчин цагийн монгол хэлэнд засаг захиргааны хамгийн том нэгж, овог аймаг, айл аймаг... зэрэг утгаар хэрэглэгдэж байна. Харин баяд, дөрвөд зэрэг аман аялгуунд баруун аймаг, зүүн аймаг хэмээн нэг сумын баг, хүмүүс бие биенээ нэрлэж байдаг нь нэг ёсондоо баруун, зүүн талаар нутагтай бие биенээ тус тус аймаг хүмүүс хэмээн үзэж ийнхүү хэлнэ. Энд эртнээс хэрэглэгдэж ирсэн аймаг гэдэг овог төрлийн холбоог заасан хам олны утга нь орон зайн хамааралтай хослон ойрад аялгууны аман ярианд хэрэглэгдсээр байгаагийн нэг жишээ болно. Баруун аймгийн айл, баруун аймгийнхны мал, баруун аймаг нүүгээд ирлээ, нүүгээд одлоо... гэх зэргээр хүмүүс нь өөр хоорондоо ярьж, ойлголцоно.

Айран хэмээх үгийг В.Далийн тольд – устай тараг, хоормог зэргийг нийлүүлж бүлээд уух татар угсаатаны ундаа; Д.Ушаковын тольд эссэн сүүгээр хийх Кавказ нутгийн ундаа; Оросын шинжлэх ухааны академийн 4 боть толь бичигт өвөрмөц хөрөнгөөр исгэсэн (Сибирь, Дундат Ази, Крымийн хойг болон Кавказ зэрэг нутаг оронд түгээмэл) сүүн ундаа хэмээн тус тус тэмдэглэв. Татарт аэрэн, хальмагт чигэн, киргизэд айран хэмээн хэлнэ. Орос-монгол толь бичигт *айран* гэдгийг *хоормог*, *цэгээ* хэмээн орчуулсан байна.

Монгол хэлний товч тайлбар тольд айраг гэдэг нь голдуу сүүг хөрөнгөлөн исгэсэн унд; гүүний айраг, үхрийн айраг гэх мэт хэмээн тэмдэглэв.

Академич Б.Я.Владимирцов энэ үгний талаар: халх аялгуунаа *аёра́к-аёри́к* хэмээх хэлбэр нь монгол бичгийн хэлний *аураг* <<напиток из кислого молока; кумыс, айран-сүүгээр исгэсэн ундаа; айраг, айран>>; манж хэлнээ *ауага*; түрэг, уйгур ... зэрэг хэлэнд *айрап*, киргиз, алтай зэрэгт *айран* ... хэмээн тэмдэглэсэн байна.

Оросын түрэг судлаач эрдэмтэн А.М.Щербакийн тэмдэглэснээр: айраг гэдэг нь эртний түрэг хэлэнд *ajrap*, монгол бичгийн хэлэнд *ajirag* - сүүг исгэж хийсэн ундаа, дундад үеийн монгол хэлэнд *ajirax*- ингэний сүү юм. Энэ үг эртний түрэг хэлний үйлээс үүссэн нэрээс үүдэлтэй бөгөөд дундад үеийн түрэг хэлний *ajig-отделять-ялгах*, салгах, тусгаарлах гэсэн үг юм гэжээ.

МНТ-нд айраг, айран гэж ороогүй, харин ...*esük cilejü odumu*... хэмээн *эсүг* гэдэг нэрээр оров (I. de Rachewiltz, index.)

Харин Орос-Монгол толийн хамгийн сүүлийн хэвлэлд *айранд хоормог*, *цэгээ*, харин *кумыс* гэдэгт *айраг* гэдгийг тус тус оноон орчуулсан байна.

Энэ үг орос хэлний толь бичигт анх тэмдэглэгдсэнийг 1835 оноор хугацаалан үздэг байна. Монгол хэлэнд *айраг*, *цагаа*, *цэгээ*, *чигээ*... зэрэг үгс байх бөгөөд нутаг нутагт өөр өөрөөр ойлгож, нэрийг оноож өгдөг байж болох юм. Төв халхад айраг гэвэл гүүний сүүгээр исгэж хийсэн сайхан ундаа; харин ойрад аялгуунд энэ үг хонь, ямаа, үнээний сүүгээр исгэж хийсэн уухын зэрэгцээ, ааруул, хурууд бэлтгэхэд зориулсан зүйл. Халхад үүнийг хоормог, цагаа гэнэ. Ойрадууд гүүний сүүгээр хийсэн ундаагаа *чигээ* гэнэ. Энэ нь цагаан гэдэг үг бага зэрэг хувирсан хэлбэр болно.

Орос хэлний толь бичигт *аксакал* хэмээх үгийг Ази тивтэй хил залгаа нутаг, татар тосгон суурин газарт өвгөн, овгийн ахлах, сонгуультан хэмээн хэлнэ, оросоор белая борода - цагаан сахал, цагаан сахалт гэсэн үг хэмээн тайлбарласан байна. Монгол

хэлний товч тайлбар тольд сахал гэдэг үгийг 1. эр хүний уруул, эрүү, шанаанд ургах үс; сахал үс; сахал самбай хорш. үг; 2. ургамлын үндэснээс гарсан нарийн салаанууд; сонгины сахал г.м. 3. гутал сөөхий мэтэд дэвсэх өвс хэмээн тайлбарласан байна.

Академич Д.Төмөртоогоо сахал хэмээх үгийн хувьслын талаар тэмдэглэхдээ: өвөг монгол хэлэнд *saqal*, эртний монгол хэлнээ *saqal*, дундат үеийн монгол хэлэнд *saqal*, орчин үеийн монгол хэлэнд *saxal* (ойрад, төв монгол, өмнөд монгол), хальмаг хэлэнд *saxäl*, буриад хэлэнд *haxal* ... гэх зэргээр бичнэ хэмээн тэмдэглэв.

МНТ-д...*Kilqo-muren-ni kinggus saqal bayan...edüi saqal uruqutala...*, ...*amun-tur saqal edüi urqutala...* (I. de Rachewiltz, index, (§§106,203 - 2611, 7813, 7814) хэмээн бичсэн нь монгол хэлнээс түрэг хэлнүүдэд орсон үг болохыг батлах бус уу. Эндээс үзэхэд *ак* хэмээх түрэг хэлний үг, *saxal* гэдэг монгол хэлний үгтэй нийлж, *аксакал* хэмээх нийлмэл үг үүссэн байна. Төрөлхи хэлний үг, харь хэлний үгтэй нийлж нийлмэл үг үүсгэх явдал аль ч хэлэнд байдаг үзэгдэл юм. Жишээлбэл, ... *Saxal* хэмээх үгийн *х* гийгүүлэгч уг нийлмэл үгний эхний үгийн *к* гийгүүлэгчид давшин ижилсэж *к* болсон байна. Акмарал нэртэй хасаг эмэгтэй оюутан байсан нь цагаан марал гэсэн нэр болно.

В.Далийн толь-д тэмдэглэснээр алтын гэдэг нь 3 мөнгөний зоосын нэр, харин татарууд ийнхүү нэрлэнэ гэв. С.Ожеговын толь-д Оросын эртний 3 мөнгөний зэс зоосны нэр. Түрэг хэлний толь бичгүүдэд алтын гэдэг бичлэгийн хэлбэртэй үг байх ба энэ нь алт гэсэн утгатай ажээ.

МХТТТ-д алт/н/ хувилахуй ухааны нэгэн язгуур махбод; шар өнгөтэй төмөрлөг эрдэнийн зүйл; давтагдан сунах чанар үлэмж хэмээн тэмдэглэв. Харин Орос-монгол толь бичиг-т гурван зоос, гурван мөнгөний зоос гэж орчуулсан байна.

Анх 1780 онд Иван Нордстетийн зохиосон герман, франц орчуулгатай орос тольд энэ үг алтынний, алтынник хэлбэрээр тэмдэглэгдэж нийтэд түгсэн байна.

Академич Б.Я.Владимирцов тэмдэглэхдээ: Орхоны бичээст *altun*, орчин цагийн түрэг хэлэнд алтын, халх аялгуунд алта, баяд аман аялгуунд алтн, өмнөд монгол аялгуунд алтан, монгол бичгийн хэлэнд *altan* хэмээн тус тус бичнэ гэжээ.

Академич Д.Төмөртоогоо: өвөг монгол хэлэнд *altan*, эртний монгол хэл, сонгодог бичгийн өмнөх үеийн монгол бичгийн хэлэнд *altan*, дундад үеийн монгол хэлэнд *altan*, орчин үеийн монгол хэлэнд *altan*... хэмээн тус тус бичиж байв гэжээ.

Н.М.Шанский нарын Орос хэлний гаралзүйн товч толь бичигт 3 копейкний ханштай оросын эртний зоос, орос хэлэнд түрэг хэлээр дамжиж орсон татар хэлний алтын - <<алт, алтан зоос>> гэдэг үг гэжээ. Орос хэлэнд энэ үг анханыхаа утгаар хэрэглэгдэж байгаад хожуу <<3 копейкний зэс зоос >> гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ.

Оросын түрэг судлаач эрдэмтэн А.М.Щербак тэмдэглэхдээ: Эртний түрэг хэлний *altun*, дундат үеийн монгол бичгийн хэлний *altan*, дундат үеийн монгол хэлний *altači* - золотых дел мастер, монгол хэлний *xaldan* ~*xardan* - золото. Тэрээр, энд тэмдэглэсэн зүйлс нь энэ үгийн гарлыг тодорхойлох үндэслэл болж чадахгүй гээд, эрдэмтэн Г.Рамстедтийн *altun* хэмээх нь нийлмэл үг ба *al* нь красный - улаан, *tun* нь - благородный метал - үнэт металл гэсэн тайлбар л үнэнд дөхөж болох юм. Тэрээр цааш нь тэмдэглэхдээ энэ нийлмэл үгийн хоёрдахь хэсэг *tun* хятад гаралтай үг гэжээ.

МНТ -ны Игорь де Рахвельзийн латин галигийн индексэд тэмдэглэснээр энэ *altan* хэмээх үг 80 гаруй удаа давтагдсаны дотор орос хэлний толь бичгүүдэд одоо байгаа хэлбэр болох алтын нь *altun* гэж орсон байна.

В.Далийн толь-д амбар, анбар гэсэн хоёр үг байх ба тэдгээрийг тариа, будаа болон бусад эд юм хадгалах сав гэж тайлбарласан байна. Д.Ушаковын тольд энэ үгийг перс хэлний *anbār* гэдэг үг ийм хэлбэртэй болсон гэжээ.

Энэ үгийн талаар Орчин цагийн оросын утга зохиолын хэлний толь бичигт тэмдэглэхдээ: Дундад үеийн орос хэлэнд XVI зууны үед тэмдэглэгдэн орж толь бичгийн хэрэглэгдэхүүн болж, улмаар зохиолчид өргөн хэрэглэх болсон үг юм. Үүнийг зарим нутагт анбар хэмээн дуудаж, бичдэг болохыг тэмдэглэсэн байна. Иран, түрэг хэлний үг гэжээ. Монгол хэлэнд үндсэн утга болох юм хум хадгалах сав гэдэг утгаар хэрэглэгдэхийн зэрэгцээ, дулааны улиралд байх хөнгөн орон сууц гэсэн утгаар хэрэглэгдэх нь их болсон байна.

Толь бичигт анджиган, анжиган, инзаган гэх мэт хэлбэрээр бичээд, гөрөөсний үр төлийн нэр гэжээ. Монгол хэлний янзага гэдэг үг орос хэлнээ дээрхи хувилбараар орсон байна. Сүүлийн үгнээс бусад хоёр нь монгол хүнд ч гэсэн танигдахад бэрх болсон. Зөвхөн тайлбарыг үзэж оноож мэдэхээс өөр аргагүй юм.

В.Далийн тольд арак гэдэг нь чихэрийн ургамал, бал бурам, цагаан будаа болон үзмийг нэрэж гаргадаг согтууруулах зүйл юм. Хасагууд арак, татарууд араки, хальмагууд эрк, хар эрк, киргизүүд арак хэмээн тус тус нэрлэнэ.

Энэ үгийн талаар орос хэлний Арвандолоотын тольд арвай, улаан буудай, шар будаа, цагаан будаа болон дал модны шүүсээр бэлтгэдэг хатуу спиртын ундаа гэжээ ССРЛЯ, I-175. Анх 1863 онд Толлийн зохиосон <<Бүх салбар ухааны лавлах ширээний толь>>-д арака хэлбэрээр тэмдэглэгдсэн байна. Араб хэлний (*araq* – хөлөс, согтуурах ундаа) үг түрэг хэлэнд *arak* болсон байна. Монгол бичгийн хэлэнд *araki* - , орчин цагийн монгол хэлэнд *ariki* -  хэмээн тус тус бичнэ. МНТ-д архи гэдэг үг ороогүй, оронд нь *darasun* хэмээн оров. ... *bö'et bor darasun-a ilaqdaqu...* (I. de Rachewiltz, index, §281-11930).

Арат хэмээх нэр В.Даль, Д.Ушаков нарын толь бичигүүдэд тэмдэглэгдээгүй, харин С.Ожеговын Орос хэлний тайлбар толь-д БНМАУ-д тариачин, хөдөлмөрчин хүн хэмээн тэмдэглэсэн байна. Оросын шинжлэх ухааны Академийн 4 боть толь бичигт: монголын тариачин, хөдөлмөрч-малчин (тал-43) хэмээн тэмдэглэв.

МХТТТ-д ард гэдэг нь 1. хуучирсан, харц олон; 2. иргэн; хотын ард; малчин ард; 3. хөдөлмөрчин олон; ажилчин, малчин, сэхээтэн монголын ард түмэн хэмээн тэмдэглэжээ.

Монгол бичгийн хэлний  - *arad*, орчин цагийн монгол хэлний *ард* гэдэг үг бөгөөд орос хэлний зүйд үг төгсгөсөн дэвсгэр -д нь -т болдог ёсоор *арат м.* хэлбэртэй болжээ. МНТ-д энэ үг ороогүй.

Аргал(аргасун) хэмээх үгийг В.Далийн тольд: Астрахань, Монгол зэрэг газар мод түлээ хүрэлцээгүй учир түлшинд хэрэглэдэг малын хатсан баас, хомоол юм. Харин Эртний түрэг хэлний толь бичигт *ayil* – овечий помёт-хонины баас хэмээн тэмдэглэв.

Академич Д.Төмөртоогоо тэмдэглэхдээ: эртний монгол хэлэнд *haγalsun*, дундад үеийн монгол хэлэнд *hargal*, орчин үеийн монгол хэлэнд *arγasan*, *arǰal* ... (МХТХЗ-158) зэрэг хэлбэртэй байна гэжээ.

Хонин гөрөөсний нэр болох аргали хэмээх үгийг В.Далийн тольд Камчаткийн хойгийн зэрлэг хонь, эр хонь; өөр нэг зүйл нь манай улсын Хятад улстай хиллэх газар болон Уртын Адаг хэмээх газар бий гэжээ.

Энэ нэр түрэг төрлийн бүх хэлүүдэд архар, arqar, аркар... гэсэн хэлбэртэй байх ба киргизээс бусад хэлэнд хонин гөрөөсний эрийн нэр гэв. Киргизэд хонин гөрөөсний эмийн нэр гэжээ. Монгол хэлэнд хүйсээр нь ялгаж өөр өөрөөр нэрлэсэн байна. *Эрийг нь угалз, эмийг нь аргали* хэмээн тус тус нэрлэнэ. А.Д.Щербак энэ үгний талаар: эртний түрэг хэлэнд *arxar*, монгол бичгийн хэлэнд *argali* хэмээн бичих ба зэрлэг хонины эмийг (РТМЯС-101) хэлнэ гэжээ.

В.Далийн тольд аргамаг гэдэг үгийг: биерхүү, үнэ ихтэй Азийн адуу гэв. тал -21. Толь бичгүүдэд дорно дахины үүлдэрийн унааны адуу, хурдан, уналгын адууны үүлдэр, дорно дахины уналгын үүлдэрийн адууны хуучин нэр, цэвэр цусны адуу, зэргээр тайлбарлан ойлгож ирсэн байна. Д.Ушаковын тольд татар хэлний *агуамаг* гэдэг үгнээс үүссэн хэмээн үзжээ. Анх 1780 онд Иван Нордстетийн зохиосон герман, франц орчуулгатай орос тольд аргамакь (ССРЛЯ, I-178) хэлбэрээр тэмдэглэгдэж нийтэд түгсэн байна.

В.Далийн тольд аркан хэмээх үгийг Дорнод татаруудад дэл, сүүлийн хялгасаар томож хийсэн зөөлөн аргамж хэмээн тайлбарлав. Энэ үгийг толь бичгүүдэд мал амьтаныг барих үзүүртэй гогцоо бүхий урт олс, дээс; адуу болон бусад мал амьтаныг барих үзүүртэй гүйдэг гогцоотой урт олс, дээс хэмээн тус тус тайлбарлан бичжээ. Харин Д.Ушаковын тольд мал амьтаныг, ихэнхидээ адуу малыг бас дайсаныг барихад хэрэглэх үзүүртэй гүйдэг гогцоо бүхий урт олс, дээс гэжээ. Гарлын хувьд түрэг үг гэв. Монгол хэлэнд яг аркан хэмээн хэлэхгүй ч аргамж гэдгийг урт сур, татлага болгож хэрэглэдэг байна. Ойрад аялгууны баяд аман аялгуунд аргамжийг *амгамж* - *amγalj* хэмээн хэлнэ. Харин энэ үгийн талаар А.Д.Щербак тэмдэглэхдээ: эртний түрэг хэлнээ *arqan*, дундад үеийн түрэг хэлэнд мөн *arqan*, дундад үеийн монгол хэлэнд *arγamji* (РТМЯС-162) хэмээн тус тус бичиж ирэв гэжээ.

МНТ-д аркан гэж ороогүй, харин ...*altan arqamji-yan sarta`ul irgen-e...* хэмээн бичжээ (I. de Rachewiltz, index, §254-10229, 256-10524). Дундад үеийн орос хэлэнд (XVII в.) аркань хэлбэрээр орос хэлэнд орсон үг. Далийн тольд энэ үгээс үйл үг, тэмдэг нэр үүсгэн тэмдэглэсэн байна.

Монгол хэлний аарц гэдэг үгийг тольд арса, арца гэж бичээд, архи нэрээд дараа нь хатааж хэрэглэх идээ; бяслаг, ааруул; монголчуудын хэвт цагаан идээ гэжээ. Энэ үг бусад толь бичгүүдэд ороогүй байна. Харин арц гэдэг үгийг В.Далийн тольд арса гээд анхилуун үнэртэн гэв. Бусад толь бичгүүдэд арца, артыш, арса, арша, *artuči*, арча, арц... зэрэг хэлбэрээр бичсэн байна. Утгын хувьд зөрөөтэй зүйл байхгүй.

В.Далийн тольд арчул гэдэг үгийг Байгалийн чанад дахь монголчуудын тамхины уут, түнгэрцэг гэсэн утгаар орсон байна. Хальмаг тольд *har*-нүүрин альчур (Русск.-Кал.С. - 496) гэж оров.

Аршан гэдэг үгийг В.Далийн тольд монголын сүм хийдийн үг, сайхан устай булаг, цэнгэг уст булаг гэж тэмдэглэв. Хасаг хэлнээ үүнийг арасан буюу эрдэс бодаст ус хэмээн хэлнэ.

МНТ-д ... yor-ıyan temüjin-e ö[k] cü temüjin-ü arca manglaitu qodoli... хэмээн тэмдэглэв (I. de Rachewiltz, index, §116-2926).

Орос хэлний толь бичгүүдэд арык хэмээх үг байх ба үүнийг усалгааны суваг, шуудуу гээд түрэг, узбек хэлний агьр хэмээх үг гэв. Хасаг, киргиз хэлнээ арык, эртний түрэг хэлэнд арык, харин монгол хэлнээ 1. арви гам; 2. зүгээр суух, дэмий суух; 3. цэвэр, тунгалаг, цэнгэг ус... (МХТТТ - 51) зэрэг утгатай ажээ.

Тайлбар толь бичигт байгаа утгуудаас гадна ойрад аялгуунд, ялангуяа баяд аман аялгуунд байнга хэрэглэгддэг нэг утга нь суваг, шуудуу гэсэн утга юм. Харин түрэг хэлнүүдэд зөвхөн энэ утга нь байж, түүнийг хэрэглэдэг байна. Зуны цагт хур бороотойд гэрээ тойруулж шуудуу ухахыг баяд аман аялгуунд *ариг авах, ариг татах, ариг малтах* гэх зэргээр хэлнэ. МНТ-д ...ökin arig usun-na töre[k]sen... хэмээн буй нь ...Ариун усан хэмээх газар төрсөн... гэжээ (I. de Rachewiltz, index, §9-608). Дундат Азийн орнуудын хэл ярианд байдаг үг. Анх 1973 онд Оросын нэвтэрхий толь бичигт водный канал-усны суваг (ССРЛЯ - 202) гэсэн утгаар орсон үг.

Аул нь Азийн ард түмний, тэр дотроо татар, башкир, киргиз, кавказынхан, хальмагуудын хот айл, тосгон, суурин, нэг дор байгаа олон байшин, гэрийг ийнхүү хэлнэ. Энэ үгийн бичлэг бүгдэд ижил байх бөгөөд харин киргизүүд айыл гэх ба садан төрлийн холбоотой хүмүүс нэг доороо байхыг хэлнэ хэмээн толь бичгүүдэд тэмдэглэв.

Харин айл гэдэг үгийг монгол хэлний толь бичгүүдэд тайлбарлахдаа: 1. нэг гэр өрх; 2. зэргэлдээ орших; айл аймаг явагчид; 3. албаны юм хадгалах газар; албаны тариа зөөх эрчүүдийг захирах мянгатын хэрэг шийтгэх газар хэмээн тус тус тайлсан байна. Харин орос-монгол толь бичгүүдэд аул гэж тэмдэглээд айл, суурин, гацаа хэмээсэн байна.

Академич Б.Ринчен айл гэдэг үгний талаар тэмдэглэхдээ: Монгол бичигт  гэдэг хэлбэр эрт дээр цагт , латинаар айил кириллээр галиглан босговол агил буюу нарийвчлавал агыл гэдэг хэлбэртэй байсан нь одоо түрэг улсын түрэг хэлнээ агыл гэж хот айл, хот хороо гэж малын хот хороог нэрлэдэг үг, бусад түрэг хэлтэнд агыл гэдэг нь сунжран хөгжсөөр авыл, аул гэх зэргийн байдалтай болж, утга санаа нь монголтой адил амуу (МБХЗ, II-246) гэж бичжээ.

Академич Д.Төмөртоогоо энэ үгний талаар: өвөг монгол хэлэнд айил, эртний монгол хэлэнд айи:l< айи:l, дундад үеийн монгол хэлэнд айи:l, орчин монгол хэлэнд айл, хальмаг, ойрад хэлэнд ä:l ... (МХТХЗ-94) гэсэн хэлбэртэй байна гэв.

МНТ-д ...dotora-ban setkiü öcigen ayil... (I. de Rachewiltz, index, §84-1904).

1835 онд нэвтэрхий толь бичигт аул гэдэг хэлбэрээр орсоноос хойш хэрэглэгдэж байна.

Дээрхи толь бичигт багана гэдэг үгийг татар хэлний үг, урт мод, гадас, шургааг, унь, тулах мод мэтээр тайлбарлав. Хасаг, татар хэлнээ багана гэдгээр, хальмаг хэлнээ бахн хэмээн тус тус хэлнэ. Монгол хэлний толь бичгүүдэд 1. юмыг тулах тулгуурдах хэрэглэл; 2. шилж. Бат түшиг тулгуур болсон хэмээн тайлбарлажээ.

Академич Д.Төмөртоогоо энэ үгийн тухайд: сонгодог монгол бичгийн хэлэнд багана, дагуур хэлэнд bahan, хальмаг хэлэнд бахān, буриад хэлэнд багана, төв монгол

хэлэнд baḡanā, өмнөд монгол хэлэнд baḡana (МХТХЗ-116) хэмээн тус тус бичнэ хэмээн тэмдэглэсэн байна.

Монгол цайны ургамалын нэр бадан хэмээх үг үндсэн утгаараа В.Далийн тольд орж үлдсэн байна. Улмаар хэд хэдэн толь бичигт монгол цай хэмээн тэмдэглэгдсэн байна. Монгол хэлэнд орсон төвөд ba dang (монгол цайнд ордог нэгэн зүйлийн өвс) (МХГҮТ-24) үг юм. 1847 онд Оросын шинжлэх ухааны академийн тольд бадан-цайны оронд хэрэглэдэг ургамал; өөрөөр, чагир буюу монгол цай гэнэ хэмээн тэмдэглэгдсэнээс хойш толь бичгийн хэрэглэгдэхүүн болсон байна.

Монгол хэлний багш хэмээх үг бакша гэдэг хэлбэрээр орж, хальмагийн гэлүн, тайлгачидын хамт байх номын багш, да лам гэсэн утгатай гэжээ. Эртний түрэг хэлний толь бичигт энэ үгийг baqš хэмээн бичнэ гээд хятад хэлний үг, багш, халамжлагч зэрэг утгатай гэжээ. Багш гэдэг үг чухам аль хэлний үг болох нь тодорхойгүй байна. Судалгааны ном зохиолд өөр өөрөөр тайлбар хийсэн байна. Жишээлбэл, эртний түрэг хэлний тольд хятад гаралтай үг гэсэн байхад өөр нэг тольд bo shi гэдэг хятад үг уйгур хэлэнд орж baxši (МХГҮТ-24) хэлбэртэй болсон гэжээ. Ямар ч гэсэн энэ үг монгол хэлэнд маш өргөн хэрэглээтэй үг болсон нь харагдаж байна.

Монгол хэлний балт хэмээх зэвсэгийн нэр үгийг орос хэлний толь бичгүүдэд балда гэсэн бичлэгийн хэлбэрээр оруулж хэрэглэх болсон ба 1. томгүй хүнд алх; 2. тэнэг, мулгуй хүн (хар яриа, хараал.) гэсэн утгаар хэрэглэж ирсэн байна. Зарим толь бичгүүдэд балду, балга зэрэг хэлбэрээр бичиж ирсэн байна. Муна гэсэн утгаар бас хэрэглэнэ гэжээ.

Орос хэлний толь бичгүүдийн тайлбараас үзэхэд энэ нь түрэг үг гэжээ. Одоо ч гэсэн энэ үг түрэг хэлт ард түмний өргөн хэрэглээтэй юм. Монгол хэлэнд сүх гэдэг үгтэй хоршиж хэрэглэгдэнэ. Лантуу гэдэг үг орлон хэрэглэгдэнэ. Утгын талаас нь авч үзвэл, монголчууд сүх, балт, лантуу зэрэг үгсийг билиг дэмбэрилтэй хэмээн үзэж хүүхдэдээ нэр болгон өгдөг байхад орос хүн тэнэг мулгуй гэсэн утгыг дагуулж ойлгодог байна. Орос хэлэнд хэдийгээр ормол үг ч гэсэн 3 утгаар хэрэглэнэ. Түрэг судлаач нэр энэ үгийг жинхэнэ түрэг үг биш, харин түрэг хэлэнд цагаадай хэлнээс орсон үг хэмээн үзнэ. Тэдний анхаарлыг төгсгөлийн -а эгшиг илүү их татдаг байна. ХҮII зууны үед орос хэлэнд түрэг хэлнээс орсон үг (ССРЛЯ-255) хэмээн үзнэ.

Бамбай гэсэн үг толь бичигт өвс, ургамалын нэр гэж орсон байна.

Барс, барыс хэлбэрээр монгол хэлний бар хэмээх үг орос хэлэнд хэрэглэгдэж хэвшсэн байна. Утга нь муурын зүйлийн том махчин амьтан гэдэг байна.

Энэ үг түрэг, монгол хэлэнд хэрэглээ ихтэй үг, МНТ-д ...bars metü balamut..., ...bars jil... хэмээн тус тус тэмдэглэгдэв (Index to the Secret History of the Mongols-78-1717; 202-7706). Монгол ярианы хэлэнд бар, монгол бичгийн хэлэнд барс гэдэг хэлбэрээр хэрэглэгдэнэ. Монгол хэлэнд үүнийг перс [bars] үг гэж үзнэ. 1780 оноос орос хэлний толь бичигт тэмдэглэгдэж эхлэсэн байна.

Монгол хэлний баатар гэдэг үгийг хэд хэдэн хувилбараар тэмдэглэгдсэний нэг нь батырь (богатырь) юм. Үгийн утгыг манай Азийнхан болон зэргэлдээ Азийнхны

хүдэр чийрэг сайхан залуу, шаламгай бөх, чин зоригт залуу, аврага, моринд гарамгай залуу... зэрэг утгаар хэрэглэнэ. Орос хэлэнд хүний нэрийн ард хэрэглэнэ, жишээлбэл, Денис-батырь, Мальханов-батырь гэх мэт.

Богатырь хэмээх үгийг В.Далийн тольд нуруу өндөр, бие том, бяр ихт, олонд алдаршсан, зориг их, эрэлхэг, хиймортой дайчин эр хүн хэмээв.

<<Краткий этимологический словарь русского языка>> хэмээхэд энэ үгийг түрэг хэлнээс эртний орос хэлэнд орсон үг. Дундат эртний монгол хэлэнд *baɣatur* - <<зоригтой, дайчин>> хэмээх утгатай байсан. Харин орос хэлний богатырь гэдэг нэр нь угтаа *богатый* хэмээх тэмдэг нэрэнд *-ырь* дагавар залгаж *богатырь* хэмээх нэр үүссэн гэжээ.

Хамгийн баттай эх сурвалж болох <<Монгол нууц товчоо>>-г сөхвөл ...*ba'atur*... гэсэн бичлэгтэй байх ба дэлгэрүүлбэл, 45-р зүйлд ...*Начин баатар*...; 48-р зүйлд ...*Бартан баатар*..., *Есүхэй* хэмээх нэр гарах тоолонд *баатар* хэмээх үг дагалдана; 149-р зүйлд ...*эзэн баатар чамайг байхад*...; 185-р зүйлд *Жүрхиний Хадаг баатар*...; 199-р зүйлд ...*Төгс баатар Сүбэдэй Төмөр царил болж*...; 226-р зүйлд ... *нэгэн мянган баатар цэргийг шилж, Архай Хасараар захируулаад*...; 268-р зүйлд *Сөнөдийн Гилүгэтэй баатар өчрүүн*... хэмээн 58 удаа гарч байгаагаас үзвэл энэ үг гарцаагүй монгол хэлний үг болов уу.

Өөр нэг жишээ дурдвал, Оросын нэрт нангиадч И.Т.Зограф <<Монгольско-китайская интерференция язык монгольской канцелярии в Китае>> нэг сэдэвт зохиолдоо хятад эх зохиолд монгол үг нэлээд байдгийг дурдаад эдгээр үг нь дуудлагын олон хувилбартайн дотор *bayatur* (<<*сильный*>>, <<*герой*>>) хэмээх үг *бадуэр*, *баатуэр*, *бату*, *батулу*, *бадулу* зэрэг хувилбартай хэмээжээ. Тэрээр цааш нь тэмдэглэхдээ; <<Юань жэнь цзацзюй сюань>> хэмээх 500 гаруй хуудастай жүжгийн зохиолд монгол үг 4 байгаа хэмээн дурдсаны дотор энэ *бадуэр*-<<*герой*>>, <<монг. *bayatur*>> хэмээх орсон байна. Энэ үгийн хэрэглээ орчин цагийн монгол хэлэнд ямар хэмжээнд байгааг зарим нэг ажиглалт, судалгааны хэрэглэгдэхүүнд тулгуурлан авч үзвэл баатар хэмээх үг дангаараа хүний нэр зэрэг оноосон нэр байхын зэрэгцээ нийлмэл нэрийн хэсэг болон олонтаа хэрэглэгддэг байна. Жишээлбэл, эрдэмтэн Ж.Сэржээгийн <<Монгол хүний нэрийн хадмал толь>>-иос түүвэрлэн үзэхэд энэ Баатар гэдэг үг монгол хүний нийлмэл нэрийн эхэнд (Баатарсүх, Баатархуяг...) орсон тохиолдол 18, мөн нэрийн хоёрдахь хэсэгт(Гэрэлтбаатар, Магнайбаатар, Сүхбаатар...) орсон 120 тохиолдол буй нь энэ нэр монгол хэлний өргөн хэрэглээтэй нэрийн нэг болох нь харагдаж байна. Энэ үгийн утгад орос хэлний рыцарь(энэ нь герман хэлний *Ritter* гэдэг үг, эртний герман хэлний *riter*-морьтон гэсэн үг) хэмээх үгийг хамааруулан үздэг байна. МНТ-д ...*sübe'tei ba'adur ügülerün*... (I. de Rachewiltz, index, §124-3312)

 - беркут, большой орёл. Ков. - 1262.

Монгол хэлний бүргэд гэдэг үг орос хэлний толь бичгүүдэд беркут хэлбэрээр орж хэрэглэгдэх болсон байна. Орос хэлэнд түрэг хэлнээс, түрэг хэлэнд дунд үеийн татар хэлнээс *burgut* орсон үг гэж үзнэ. Энэ нэр монгол хэлэнд нэлээд билэгдэлтэй үг, улмаар хүүхдэд өгөх билиг дэмбэрлэлтэй нэрийн нэг юм.

Богдхаан хэмээх нэр богдыхан гэсэн хэлбэрээр орсон байна. Хятадын эзэн хааны хэргэм гэжээ. Монгол хэлнээ богд хаан, богд эзэн хэмээн хэлж заншсан үг. Түүхэн тодорхой үед хэрэглэгдэж байсан хятадаас монголд суулгасан ариун эзэн гэсэн утгаар

хэрэглэгдэж байв. Энд нийлмэл үг болгож бичсэн байна. МНТ-д богд хэмээх үг тэмдэглэгдээгүй, харин хаан...cinggis-qahan..., ...cinggis qa'an-a... гэдэг үг олон гарна. (Index to the Secret History of the Mongols-78-1717, 7706).

 - сталь, уклад, булат. Ков. - 1190.

Орос хэлний толь бичгүүдэд булат гэсэн үг байх ба энэ нь түрэг төрлийн хэлнүүдэд булат, болат, болот зэрэг хувилбараар бичиж, хэрэглэж байна. Энэ нь сайн чанарын ган төмөрийн нэр, улмаар оноосон нэр болсон байна. Эртний түрэг хэлний тольд bulat гэдэг нь оноосон нэр гэжээ. Оросын хэл шинжээчид энэ нэр перс хэлний pūlād гэдэг үг ийм хэлбэртэй болсон гэж үздэг байна.

Үгийн гаралзүй судлаач Оросын эрдэмтэн П.Я.Черных тэмдэглэхдээ: перс хэлэндээ - фулад: пулад - <<сталь>>; курдад пола: полат; таджикт пуулад, осетинд bolat; афганистанд фулад, казах-татар зэрэг хэлэнд булат; киргизд болот (ИЭССРЯ-122) зэргээр хэлж, бичдэг. Нордстеттийн тольд 1780 онд булат, булатный гэсэн хэлбэрээр орсон, Далийн тольд булатовый, булатка, булатчик, булатить зэргээр үг үүсгэн тэмдэглэв.

Буртаг, булингар зэрэг үгсийн бичлэг бага зэрэг өөрчлөгдөж бурда гэсэн хэлбэрээр орос хэлний толь бичгүүдэд орсон бололтой. Аливаа булингартсан, уухад эвгүй болсон шингэн зүйл хэмээн тайлбарласан байна. Түрэг хэлний бурда гэдэг үг орос хэлэнд орсон хэмээн үздэг байна. Энэ үг түрэг хэлтэн улсуудын толь бичгүүдэд тааралдахгүй байна. Зөвхөн орос хэлний тольд тэмдэглэгдэж нэгээс нэгд орсон бололтой. Буртаг хэмээх үг ийм хэлбэртэй болоод байж болох юм.

Орос хэлний толь бичгүүдэд бурун гэсэн үг байх бөгөөд эрэгээ болон хадан хясааг цохиод буцах далайн давалгааг ийнхүү нэрлэнэ. Мөн Сибирь нутагт бухан бярууг ийнхүү нэрлэнэ гэжээ.

Монгол хэлний бяруу гэдэг үг орос хэлний тайлбар толь бичигт орсон хэлбэр нь юм. Зарим орос хэлээрхи ном зохиолд бурун, бурунчик... зэргээр бичсэн байдаг.

Монголчуудын шүтээн болох бурхан гэдэг үг орос хэлэнд энэ үгийн бичлэг, утга орсон байна.

МНТ-д ...qasin irgen-ü burqan elsen... хэмээн гарна, мөн газар усны нэрээр ч энэ үг гарна (I. de Rachewiltz, index, §249-10021).

Түүнчлэн энэ үг монгол хэл аялгуунуудад ямар хэлбэртэй болсоныг академич Д.Төмөртоогоо тэмдэглэхдээ: Сонгодог монгол бичгийн хэлэнд burqan, эртний монгол хэлэнд burqan, дундад үеийн монгол хэлэнд burqan, орчин үеийн монгол хэлэнд (хальмаг, ойрад, буриад, төв болон өмнөд монгол) ... burqan гэж байна(МХТХЗ-164).

Гаанс хэмээх тамхи татах хэрэгсэлийн нэр дээрхи толь бичигт ганза гэдэг хэлбэртэй орж, Сибирийн монголчуул буюу хятадын тамхи татах гаанс гэж тайлбарлав. Бичлэгийн байдлаас үзэхэд энэхүү нэрийг ойрадууд ганз хэмээн хэлнэ. Тэгэхлээр хальмагууд юм уу буриадуудын хэлнээс орсон үг бололтой. Монгол бичгийн хэлний бичлэгийг авсан байна.

Хятад хэлнээс монгол хэлэнд орсон *gān zī* - тамхи татах хэрэгсэлийн нэр болно. Хальмаг, буриад хэлнээс орос хэлэнд орсон үг хэмээн үзэж болох юм.

Гич хэмээх ургамлын нэр В.Далийн тольд тэмдэглэгдсэн үг, бусад толиудад ороогүй байна. Монгол хэлний гич хэмээх халуун ногооны нэр, оросоор горчица юм.

Хужир гэдэг нэр гуджир хэлбэрээр бичиж, солонец, солончак - хужир, мараа хэмээн тайлбарласан байна.

Монгол хэлний эр хүйст гурван настай малын нэрийг гунак, гуначик хэмээн жижгэрүүлэн өхөөрдөх хэлбэрт оруулж толь бичигт тэмдэглэсэн байна. Тэрээр гурван настай тугалыг хэлнэ гэв. Харин энд хүйсийн ялгаа гаргаж бичээгүй байна.

Харин гуран гэдэг үгийг зэрлэг эр ямаа гэж тэмдэглэв.

Монгол хэлний гутал гэдэг үгийг орос хэлний хос эд зүйлийн нэрийн хэлбэрийг дагуулан гутулы гэсэн хэлбэрээр бичиж, толь бичигт оруулсан байна. Энэ нь зузаан өсгийтэй хар ажлын савхин гутал(бахиаал) гутал гэв. В.Далийн толийн Х үсгийн толгойнд хутулы гэж оруулаад бойтог, зөөлөн илгэн арьсаар хийсэн савхин гутал хэмээн тайлбарлав. Хутулы-г бас бойтог, эсгий гутал зэргийн гадуур өмсөнө гэв. Харин энэ үгтэй нэг язгууртай үг болгож гуталин гэсэн үг оруулаад арьсан гутлын тос гэжээ. Гэтэл Д.Ушаковын тольд энэ нь герман хэлний үг бөгөөд Gut гэдэг нь сайн гэсэн үг, oilum гэдэг нь тос хэмээсэн үг болно хэмээн тайлбарласан байна.

Их тайлбар тольд орсон хэлбэрийг харахад хос хосоор байх, хэрэглэгдэх зүйлийг орос хэлэнд олон тоот хэлбэр болох -ы нөхцөлийг дагуулдаг ёсоор *гутулы* болгож нэг ёсондоо *боты, бахилы, сапоги* хэмээн орос хэлэнд хосоор байх зүйлийн бичлэгийн хэлбэрт орж хэвшсэн байна. Харин сүүлдээ үндсэн утга нь өөрчлөгдөж, улмаар түүнийг өнгө, үзмэжтэй болгодог зүйлийн нэр болж хувирсан байна. Их тайлбар тольд 1934 онд тэмдэглэгдсэн үг гэжээ.

МНТ-д ...qudusun, de`el... (I. de Rachewiltz, index, §145-4106)

Монгол хэлний даавуу гэдгийг даба гээд Сибирь нутагт хэлнэ, хятад хэлний үг гэв. Монгол хэлэнд хятад хэлнээс [da`bu`] орсон үг, улмаар монгол хэлээр дамжиж орос хэлэнд орсон байж болох юм. 1847 онд Оросын Академийн толь бичигт даба гэсэн хэлбэрээр энэ үг (ССРЛЯ-III-516) орж тэмдэглэгдсэн байна.

Даган, даганчик гэж астрахань, хальмаг, Сибирь зэрэг нутагт хэлнэ, Энэ нь хоёр настай адуу гэв. Орос хэлний хүн, амьтан, юмыг өхөөрдөх, жижигхэн гэсэн утгыг илэрхийлэх -чик дагаврыг залгаж даганчик гэдэг үгийг үүсгэсэн байна. Энэ нь хөөрхөн, жижигхэн адуу гэсэн утгатай юм.

МНТ-д ...üri`e da`aqan surqaqu...(Index to the Secret History of the Mongols, 149-4425,4426)

Орос хэлний толь бичигт бичлэгийн зөв хэлбэрээр Далай-лама гэж орсон байна. Төвэд улсын дээд захирагч ба төвэдийн сүм хийдийн тэргүүн юм. 1803 онд зохиогдсон Н.Яновскийн <<Шинэ үгний тайлбар>> хэмээх тольд энэ үг анх Төвэдийн бурханы

шашинт санваартнуудын тэргүүн, төвөдийн хаан (ССРЛЯ-II -539) гэсэн тайлбартайгаар орос хэлэнд орсон байна.

Харин энэ лама хэмээх үг дэлхийн бүх хэлэнд монг.  төвэд хэлний blam-a, оросод лама, англид - lama, францад - lama... гэж байхад ганц монгол хэлэнд лам болгож хэрэглэдэг нь сонин юм. Өөрөөр хэлбэл, кирилл үсгээр бичсэн ном зохиолоос энэ үгийг нэрлэхийн тийн ялгал ганц тоот хэлбэрээр эс таних, түүнийг нэрлэхийн тийн ялгал ганц тоот хэлбэрт байгааг нь харсан орос хүн харъяалахын тийн ялгал, олон тоот хэлбэрээр - лама нарын, ламуудын хэмээн ойлгох болж байна. Гадаад хэлний үгийг аливаа хэлэнд идээшүүлэхдээ түүний хэлбэрийг аль болохоор хадгалахыг хичээдэг зарчимтай билээ. Бид монгол бичгийн хэлэнд байсан хэлбэрээр нь ярьж, бичиж хэвшүүлбэл энэ мэтийн эндүүрэл гарахгүй юм.

Дах хэмээх хувцасыг даха, доха гэсэн хоёр хувилбараар бичээд үсийг нь гадагш, дотогш харуулж өмсөх үстэй дээл; дахыг унага, буга, гөрөөс, хонины арьсаар хийнэ. Сибирь, Оренбург зэрэг нутагт хэрэглэнэ гэв.

Оросын Шинжлэх Ухааны Академиас 1895 онд гаргасан толь бичигт анх доха хэмээх хэлбэрээр орсон үг, даха, доха (ССРЛЯ-III-1066) гэсэн хоёр хэлбэрээр бичиж иржээ.

МНТ-д ...buluqan daqu abciraju...(I. de Rachewiltz, index, §95-2201)

В.Далийн тольд дацан гэж оруулаад мөргөлч лам нар, хальмаг, буриадуудын сүм. Харин Д.Ушаковын тольд дацанг буриадууд, хальмагууд болон буддистуудын бурхан шүтээндээ мөргөх газар гэв. Энэ нь төвэдээс [gra tshang] монгол хэлэнд орсон үг гэжээ.

Дэвтэр гэдэг үгийг дефтер хэмээн бичээд гааль, алба татвар, гувчуур авах тухай татарын хааны зарлиг бичиг гэж тайлбарлаж оруулав.

МНТ-д ...kökө debter bicik bicijü debterlejü... (I. de Rachewiltz, index, §203-7829)

Д.Ушаковын тольд есаул хэмээх үгийг цагаадай хэлний *jasaul* үг гээд, хувьсгалын өмнө хасаг цэргийн суман дарга, ахмадын зэрэгт дүйцэх даргын зэрэг дэв. Орчуулбал *зарлиг гүйцэтгэгч* гэсэн үг гэжээ. Энэ бол монгол хэлний засуул гэдэг үг бөгөөд монгол бичгээр  хэмээн бичнэ.

Монгол бичгийн хэлний жидэ гэдэг үгийг орос толь бичигт джида гэж оруулаад гуравхан сумын байртай жижиг саадаг гэжээ.

МНТ-д ...dōro jida kebte`ül asara... (I. de Rachewiltz, index, §232-9124).

Зээр гэдэг үгийг орос хэлний толь бичгүүдэд джейран, дзерен, жирен, жэйран, зерен гэдэг таван хувилбараар оруулж, Өмнөд, Дундад, Төв Азийн цөл, хагас цөл, Кавкахстан, мөн перс, хятад зэрэг улсын хилээр нутагшсан жижиг биетэй гөрөөс, монгол, киргиз улсын нутгийн хар сүүлт гөрөөс гэж тайлбарласан байна.

Орос хэлний 17-ын тольд тэмдэглэснээр Яны Чингис-хан номоос анх орсон үг хэмээн тэмдэглэв.

Зуд хэмээх байгалийн бэрхшээлийн нэрийг, йот гэж толь бичигт оруулаад, өвлийн улиралд өвс ургамлыг ашиглах боломжгүйгээс мал сүрэг олон тоогоор үхэж хорогдохыг хэлнэ гэжээ.

Дөнө дөнөн хэмээх хүйс, нас заасан үгийг дунан гэж бичээд, монгол хэлний үг, оренбургийн худалдаачдын ярианаас...киргизэд гурван настай эр хонь, сибирьт дөрвөн настай үхэр, адуу хэмээн тус тус тайлбарласан байна. 1954 онд хэвлэгдсэн ССРЛЯ-д тэмдэглэгдсэн байна.

Эмээлийн тоногийн нэг жирэм гэдэг үгийг жирим, джирим гэсэн хоёр хувилбараар толь бичигт оруулж, Дорнод сибирьт эмээлийн олом жирэм хэмээн тайлбарласан байна.

Ирвэс гэдгийг ирбис, ирвсг гэж тэмдэглээд, монгол хэлний үг, муурын багийн сүүн тэжээлт махчин амьтан, цасны барс ч гэж хэлнэ хэмээн тайлбарлажээ.

Монгол ярианы хэлний ирэг хэмээх үгийг ирген, ирга, ирха, ирик зэрэг хувилбараар бичиж, монгол хэлнээс сибирийн хэлэнд орсон үг, агталсан эр хонь, мөн илэг болгон элдсэн ямаа, хонины арьсыг бас ийнхүү хэлнэ гэж тайлбарлав.

МНТ-д ...minqan irges ta'uju ... (I. de Rachewiltz, index, §182-6214)

Монгол хэлний хайс хайсан гэдэг үг орос хэлний толь бичгүүдэд өөрчлөгдсөн хийгээд казан хээсн гэдэг хэлбэрээр орж хэрэглэгдэх болсон бололтой. Энэ нь түрэг хэлний казан гэсэн үг гэжээ. Нутгийн аялгууны үг гэсэн байна. Олон хүний хоол хийх тогоог хэлнэ гэв.

Ангийн хэрэгсэлийн нэг хавх гэдэг үгийг капкан, капкын гэж бичээд, зэрлэг амьтаныг хөлөөр барих хэрэгсэл; ярианы хэлэнд занганд орох гэж бас хэлнэ. Энэ нь түрэг хэлний каркан гэдэг үг гэв. 17-тын тольд энэ үг орос хэлэнд 1792 онд Академийн тольд тэмдэглэгдсэн үг гэжээ. Оросын газрын зурагт Крымийн хойгт Кардаг-Kara Daga гэсэн эртний галт уулын нэр байна. Энэ бол Хар дааганы уул гэдэг нэрээс өөрөөр байхын аргагүй юм. Монгол Улсын зарим аймгийн нутагт Хар дааган, Бор дааган, Хүрэн морьт, Хар азаргын нуруу... зэрэг адуу малын нэртэй газар олон байна. Монгол бичгийн хэлнээс үсгийн галигаар буулгасан нэр байна. Энэ хоршоо үг яваандаа ярианы хэлний нөлөөгөөр нийлж нэг үгийн хэлбэртэй болсон байна. Энэ бол нийлмэл үг, монгол хэлний үг болно. Газрын зурагт манай улстай хил залгаа улсын нутагт өнөөдрийн монгол хэлэнд байгаа хэлбэрээрээ буй үг олон байгааг энд эс дурдав. Зөвхөн онцлог цөөн үгийг сонгож тайлбар хийхийг хичээв.

Эцэг малын нэр хуц гэхийг орос хэлэнд куцан хэмээн тэмдэглээд агтлаагүй эр хонь, хонины эрийг хэлнэ гэжээ.

Ойрад аялгууны харгай мод гэдэг үгийг орос тольд карагач, карагайдын, карагай хэлбэрээр орж, утгыг нь шинэс модыг хэлнэ гэжээ. Энэ үг түрэг хэлний кара agak гэсэн үг гэв.

Монгол хэлний харандаа гэдэг бичих хэрэгсэлийн нэрийг карандаш хэмээн бичээд, түрэг хэлний *kara* - чёрный и *tash* или *tach* – камень гэсэн үгнээс үүссэн гэжээ. Энэ үг 1731 онд Вейсманновын тольд карандаш (ССРЛЯ, V-802, 803) гэж, 1708 оны 12-р сарын 19-ны өдөр Их Петерийн захидалд ...карандашем... (ИЭССРЯ, I-379) гэсэн хэлбэрээр орсноос хойш хэрэглэгдэх болсон үг гэж үздэг байна.

Харуул хамгаалалтыг караул хэмээн бичээд, хамгаалах алба үүрэг бүхий цэргийн анги, мөн тийм үүрэг бүхий хүн гэжээ. Энэ нь цагаадай хэлний *karayul* гэсэн үг хэмээн тэмдэглэв. 1704 онд хэвлэгдэн гарсан Ф.Поликарповын слав, эртний герег, латин хэлнүүдийн сан хөмөргийн тольд караул гэдэг хэлбэрээр орсон байна. Орчин цагийн орос хэлний түүхэн гаралзүйн тольд түрэг хэлний *кара-смотреть* гэдэг үгэнд монгол хэлний *есаул* гэдэг үгэнд ордог -ул дагаврыг залгаж үүссэн үг (ИЭССРЯ, I-380) гэжээ.

МНТ-д ...*sa`urin qara`ul talbi`ulba*... (I. de Rachewiltz, index, §142-4005). Орос хэлэнд карий гэсэн тэмдэг үг байх бөгөөд энэ нь түрэг хэлний *kara* – хар гэсэн үгнээс үүссэн, адууны зүсэнд хар хээр, нүдэнд хархан гэсэн утгатай гэжээ. 1771 онд хэвлэгдэн гарсан орос хэлний гаралзүйн тольд түрэг хэлнээс *кара-чёрный* гэсэн утгатай үг орсон гэжээ.

Хул, хулан адууны зүс, адуун гөрөөсний нэр зэргийг орос толь бичгүүдэд кула, кулан хэмээн тэмдэглээд, орос хэлний *саврасый*, дикий осёл зэрэг үгнүүдээр орчуулна гэжээ.

МНТ-д ... *uqurqatu qulan*... (I. de Rachewiltz, index, §199-7405).

Блама хэмээх төвөд үгийг лама хэмээн тэмдэглээд, бурханы шашинтаны санваартан-ламыг хэлнэ гэжээ. Н.Яновскийн шинэ үгсийн тайлбар цувралын 1804 оны дугаарт анх лама, академийн толь бичигт 1847 онд лама гэдэг хэлбэрээр тус тус орсон ба утгаа төвөд хэлний *blama* (ССРЛЯ, VI-48) хэмээх үг юм.

Монгол хэлний малгай гэдэг нэрийг малахай, махлай, махлан, махалай, макалай... зэрэг хувилбараар бичиж, дорно дахины хүмүүсийн өмсөх том чихтэй буулгаж өмсөх арьсан үстэй малгай гэж тайлбарласан байна. Д.Ушаковын тольд хальмаг хэлний *makhle* гэдэг үг ийм болсон гэжээ. Орос хэлний тайлбар тольд дээр үеийн тариачны чихтэй том арьсан малгай гэжээ.

1793 онд Оросын Академиас гаргасан тольд анх хальмаг хэлний *махла* гэдэг үг малахай (ССРЛЯ, VI-522) гэдэг хэлбэртэй болж орсон юм.

МНТ-д ...*Jelme maqalai qudusun de`el*... (I. de Rachewiltz, index, §145-4106)

Мангир хэмээх ургамлын нэр толь бичигт орж, Байгалын чанадад ургадаг зэрлэг сонгино хэмээн тайлбарлажээ.

МНТ-д ... *qoqosun manggisu-`ar teji`ekset*... (I. de Rachewiltz, index, §75-1615)

Марал хэмээх нэр орос толь бичгүүдэд орж, баруун Сибирийн үхэр гөрөөс, дорнод Сибирийн жинхэнэ буга хэмээн тайлбарлав. С.Ожеговын тольд том эвэртэй сибирийн том буга, Киргиз-орос тольд бугын эм нь буюу марала хэмээн бичжээ.

1793 онд Оросын Академийн тольд марал (ССРЛЯ, VI-620) гэж орсон байна.

МНТ-д ...qo'ai-maral aji'ai... (Index to the Secret History of the Mongols, 1-502).

Орос хэлний толь бичгүүдэд мерен, мерин гэсэн үгийг В.Даль монгол хэлний мерин гэдэг үг, харин Д.Ушаков энэ үгийг хальмаг хэлний mērin гэдэг ийм болсон хэмээн тайлбарласан байна. Агталсан адууг хэлнэ гэжээ. Киргизүүд атан тэмээг верблюд-мерин гэж бас хэлдэг байна. Монгол аялгуунуудад морин, мөрн, морн... зэргээр хэлнэ. Энэ үг хальмаг хэлээр дамжиж орос хэлэнд орсон үг байж таарна. Ер нь лошадь гэдэг үг ч түрэг үгнээс үүссэн хэмээн тайлбарласан байна.

1731 онд гарсан Вейсманновын толь, 1771 онд гарсан оросын гаралзүйн тольд мерен гэсэн хэлбэрээр, 1780 гарсан Нордстеттийн тольд мерин хэмээн тус тус орсон байна.

МНТ-д ...morin ber... (I. de Rachewiltz, index, §31-823)

 - куча, груда камней; насыпь, межевой знак, обо.

Овоо хэмээх үгийг обонь гэдэг хэлбэрээр оруулаад, хятадын манайхтай залгаа хил дагуух баримжаа авах овоолсон шорой, чулуу; буриадуудын мөргөл хийх овоо шорой, чулууг обо гэнэ хэмээн тус тус тайлбарласан байна.

Панты гэдэг үгийг В.Даль, Д.Ушаков нар монгол үг гээд, бугын залуу эвэр, эмийн түүхий эд болгож хятадууд их авдаг зүйл гэжээ. Энэ бол бугын цусан эвэр юм. Манж хэлний фуньту, нанай хэлний пунту (ССРЛЯ, IX-126) гэдэг үгсээс энэ үг үүссэн болно.

Саадаг хэмээх үгийг садакъ, сагайдак, сайдак зэрэг хэлбэрт оруулаад, татар үг гэжээ. Харин Д.Ушаковын тольд садак хэмээх нь түрэг үг гэжээ. Нум, сумыг дүрж зүйх алт, мөнгөн чимэгтэй ширэн сав хэмээн тайлбарлав.

1847 онд гарсан Академийн тольд түрэг хэлний sādaq (ССРЛЯ, XIII-25) гэдэг үг саадак хэлбэрээр оржээ. Оросын зохиолч А.К.Толстойн <<Мөнгөн ноён>> хэмээх романд <<...Бросился Борис к коновязи, где стоял конь с саадаком, вскочил в седло...>> гэсэн өгүүлбэр байх бөгөөд үүнийг <<...Борис саадагч морины уяанд байсан саадагтай морины зүг очиж, ухасхийн мордоод... >> хэмээн нэрт дуун хөрвүүлэгч Б.Ринчен орчуулжээ.

Сав гэдэг нэрийг киргизчүүдийн айрагаа хийдэг хамгийн том арьсан савын нэр, кавказ нутагт үүнийг бурдюк буюу хөхүүр хэмээнэ гэжээ.

МНТ-д ...ayaqa saba asaraqsat... (I. de Rachewiltz, index, §187-6410)

 - борода.

МНТ-д ...kinggüs saqal bayan...; edüi saqal uruqutala öscü... (I. de Rachewiltz, index, 105-2611; 203-7813)

Сарай гэдэг үгийг Дальд татар хэлний, Ушаковд saraj хэмээх түрэг хэлний үг гэжээ. Ачаа, бараа, морь малын тоног хэрэгсэл, зарим үед өвс, сүрэг зэргийг хадгалахад зориулж орон байрны хажууд барьсан битүү байр гэжээ. Орос-монгол тольд энэ үгийг саравч, пин хэмээн орчуулжээ. 1731 онд Вейсмановын тольд, 1771 онд Оросын

гаралзүйн тольд сарай гэдэг хэлбэрээр тус тус оров. Энэ нь перс хэлнээс sarāi, sarā - дворец, дом (ССРЛЯ, 182) гэдэг үг түрэг хэлэнд орсон үг юм.

Толь бичигт сарана гэсэн үг байх ба оросоор лилия (ССРЛЯ, XIII-183) бөгөөд монголоор сараана, сараанын цэцэг юм.

Ярианы хэлэнд таар, таар шуудай хэмээн хэлэх үгийг орос толь бичигт таар гээд, гэрийн нөхцөлд босон суун сүлжиж, шалны алчуур, малын нэмнээ, ажлын гадуур хувцас зэргийг хийх даавуурхуу зүйл хэмээн тайлбарлажээ.

Сарлаг хэмээх малын нэрийг монгол бичгийн хэлбэрээс сарлукъ хэмээн буулгаад монгол юм уу төвэд нутгийн үхэр; бөгтрөгтэй үхэр ч гэмээр юм уу? Хэмээн тайлбарлав. 1858 онд Академийн толь бичигт тэмдэглэгдэж үлдсэн үг. Монг. Sarlag, хальмагт sarlāg (ССРЛЯ, XIII-191) гэнэ.

Солонго хэмээх бяцхан махчин амьтаны нэрийг солонгой хэмээн бичээд, хүрэн, бяцхан хүрэн гэж тайлбарлажээ. 1858 онд Академиас хэвлүүлсэн нутгийн аялгууны тольд солонгой (ССРЛЯ, XIV-235, 236) гэж орсон байна.

МНТ-д ...solangqa bolju... (I. de Rachewiltz, index, §103-2335)

Сундлах хэмээх үйл үгийг сундала, сундулой гэж Сибирь, Монгол нутагт ярина. Энэ нь унаагаар хожуул явах, нэг морин дээр урдах хүнийхээ хойно нь сууж явахыг хэлнэ. МНТ-ны орос орчуулгад байгаа энэ үгийг өгүүлбэрийн хамт авч үзвэл:

...Борохул, а сзади него <<сундлатом>> (вдвоём) сидит и Огодай... - ...Өгөөдэйн хойноос Борохул сундалж... (С.Козин., Сокровенное сказание Монгольское хроника 1240 г. под названием mongol-un niguča tobčiyān., § 173).

В.Далийн тольд сундуй хэмээн бичээд, гөжүүн, хөшүүн, болхи хүн гэсэн утгатай үг гэв. Энэ бол монгол хэлэнд зохион байгуулалтгүй, эмх цэгцгүй... гэсэн утгаар хэрэглэгддэг ундуй сундуй хэмээх хоршоо үгийн нэг болно.

Табарган, тарбаган гээд, сибирь нутгийн алагдай, нүхний туулай гээд, нүхэнд байдаг, өвөл ичдэг амьтан гэв. Энэ үгийг хальмагт тарвхан гэж хэлдэг байна. Монгол хэлний tarbaγan гэсэн үг юм.

1858 онд хэвлэгдсэн нутгийн аялгууны тольд тарбаган, монгол хэлний tarbaγan (ССРЛЯ, XV-123) хэмээсэн үг гэжээ.

1794 онд хэвлэгдсэн Академийн тольд табарган гэдэг хэлбэрээр оржээ(ССРЛЯ, ХҮ-8).

Тайга хэмээх үгийг толь бичгүүдэд энэ хэвээр нь тэмдэглээд, гарлыг нь янз янзаар тайлбарласаар иржээ. Д.Ушаков якут хэлний тайга - лес гэсэн үг, СССР-ийн Академийн тольд түрэг хэлний тайга гэдэг үг гэжээ. Энэ нь Европ, Азийн хойгуур байдаг зэлүүд, явахад бэрх ой юм гэжээ.

1847 оны Академийн тольд тайга, 1852 онд Академиас гаргасан нутгийн аялгууны тольд тайга, улмаар монгол хэлний oj taija (ССРЛЯ, ХҮ-32) гэсэн үг гэжээ.

Тайлга хэмээх үгийг тайлаган гэж бичээд буриадуудын бөөгийн шашны баяр; өндөрлөг газар гал түлж, адуу гаргаж шарж идээд, арьс толгойг нь Их эзэн савдагтаа хувь болгон урт модонд өлгөж орхиод явна гэж тайлбарласан байна.

Тайж гэдгийг тайша хэмээгээд, хальмагийн эзэн, ахлах хүн, ноёноос доогуур.

Монгол хэлэнд цалгай, назгай гэдэг тэмдэг үг байх ба түүнийг талагай хэмээн толь бичигт оруулаад, залхуу, хойрго, урихаас өөрийг мэдэхгүй гэжээ.

Туулай гэдэг үгийг толь бичгүүдэд талай, тулай, толой, толуй, толай зэрэг олон хувилбараар бичээд, Алтайн уулын туулай; уул, талын туулай, Байгалын чанад нутгийн туулай, монголын туулай гэх зэргээр тайлбарлав.

МНТ-д *taulai jil sarta`ul irgen-tür...* (I. de Rachewiltz, index, §257-10533)

 - кожанный мешок. Ков. 1855

Тамга, им, тэмдэгийг тамга гээд түрэг хэлний *tamqa* гэсэн үг гээд зарим нүүдэлчидийн хувийн өмчийн тэмдэг, татар, башкир, орос газар хэрэглэдэг байсан талаар толь бичигт тэмдэглэв. 1771 онд хэвлэгдсэн Орос хэлний гаралзүйн тольд тамга хэмээн тэмдэглэгдэв. Энэ нь түрэг хэлний *tamqa* гэсэн үг юм(ССРЛЯ, ХҮ-91).

Дархан хэмээх үгийг орос хэлэнд эхний д гийгүүлэгчийг т гийгүүлэгчээр сэлгүүлэн тархан хэмээн бичсэн байна. Феодалын байгуулалттай Оросод монголын язгууртны хүрээллийн хийгээд санваартан ихсийн төлөөлөгч, түүнчлэн газрын албан татвараас чөлөөлөгдөж, онцгой эрх дархатай болсон эзэн. Энэ нь монгол хэлний эрхтэн-дархатан гэсэн утгатай юм. Яг оноовол дархан хүмүүс гэсэн үг ийм хэлбэрээр орос хэлний толь бичгүүдэд орсон байна. Энэ үгний нэрлэхийн тийн ялгал олон тоот хэлбэр нь тархане буюу горожанин-горожане гэдэгтэй адил хэлбэр юм. Монгол бичгийн хэлэнд . *darqan*, кирилл үсгээр бол дархан гэнэ. Монгол бичгээс тэр болгон монгол хэлийг сайн мэдэхгүй хүн *tarqan* -тархан гээд л биччихнэ. Мөн монгол хэлэнд нутаг нутгийн аялгуунд үгийн эхний т гийгүүлэгчийг д -ээр дуудах, жишээлбэл, ташуурыг дашуур, талх гэхийг далх гэх мэтээр т гийгүүлэгчийг д-ээр сэлгүүлэн хэлэх нь бий.

Тараг гэдэг үг толь бичигт орсон байна. Энэ үгийг аарцны төрлийн зүйл гэж тайлбарлав.

Дарс хэмээх нэрийг тарасун гээд архийг дахин нэрж гаргасан архины нэр гэжээ.

Тэх гэдэг нэрийг текъ, тыкен, теке, текей зэрэг хувилбараар бичээд, Алтайн ямаан гөрөөсний ухна, хөнгөлөөгүй эр ямаа... гэж тайлбарлав.

Таваар хэмээх үгийг түрэг хэлнээ *davar*, азербайжан хэлэнд *davar*, башкирт *mal-tivar*, *tirlik*, хасаг хэлнээ *uvak mal*, *candik*, *koy-ecki*, өзбек хэлэнд *usak-mal*, татарт *tirlik*, *mal-tuar*, *mal*, түркмен хэлэнд *dovar*, уйгурт *carvd*, *koy-цшкд* дээрхи хэлнүүдийн үгийг оросоор орчуулбал мелкий погатый скот (Türk Lehzeleri sözlüğü-150, 151), хальмаг

хэлнээ тавр, эд-тавр гэнэ. Н.М.Шанский нарын эрдэмтэд энэ нь түрэг гаралтай үг бөгөөд анхандаа мал гэсэн утгатай байснаа хожим нь энэ нь эд зүйл гэсэн утгатай болсон. Учир нь нүүдэлчин ард түмний гол баялаг, эд зүйл нь мал байсан бөгөөд солилцооны хэрэгсэл (Кратк.Этим. Сл. Русск. языка-444) болж байжээ.

Тойн лам гэдгийг тойн гэж бичээд, сонгуультан, харийнханы ахлагч хэмээн тайлбарлав.

Торлиг модын нэрийг торлук хэмээн бичээд, бут мод хэмээн тайлбарлав.

Тулам гэдэг үгийг тулун гээд, бүтүүгээр өвчиж авсан арьс гэж тайлбарлав. Туламлах гэдгийг тулунить хэмээн тэмдэглэв. Бас тулун гэж бичээд, монгол хэлний үг, дорнод Сибирьт турсук, оренбург мужид хөхүүр, Кавказад элдэж, утаж хийсэн арьсан уут; ус, унд зөөвөрлөхөд хэрэглэнэ гэв.

Тэмээг тымен, темэн хэмээн бичээд, монгол, сибирь, оренбургийн хоёр бөхтэй тэмээ гэв.

МНТ-д ...sartaqtaï caqān teme'tü... (I. de Rachewiltz, index, §182-6214)

Нохой тухирах ту ту гэдгийг тю гээд, хоточ нохойг тухирах үг гэж тайлбарлав.

Уурга хэмээх үгийг укрюк, урган гэж бичээд, курук гэсэн татар үг байх? Энэ нь үзүүртэй гогцоотой дээс, аргамж бүхий хөнгөхөн шургааг мод юм. Үүгээр бэлчээрт яваа адууг барихад хэрэглэнэ гэжээ.

МНТ-д ...moritu gu'un u'urqa bariju qaqa'ar... (I. de Rachewiltz, index, §91-11818)

Улаа гаргах гэдэг үгийг улала(о)каты гээд, үйлийн объект заахын тийн ялгалд байна гээд алах, гаргах гэсэн үг гэж тайлбарлав.

Улаач гэдэг үгийг улачи гэж бичээд, үүнийгээ олон тоот хэлбэр гэж үздэг байна. Өртөөний албыг гүйцэтгэгчийн нэр гэжээ. Байгалын чанад, Буриад нутагт ийнхүү хэлнэ.

МНТ-д ... minqat minqat-asa jamucin ula'acin qarqaju... (I. de Rachewiltz, index, §279-11818)

Монгол хэлний ойрад аялгуунд улир хэмээх шувууны нэрийг улар хэмээн бичээд, гургуулын овгийн шувуу, хойлогч гэж хэлнэ. Пржевал.От Кяхты на истоки Желт. реки. Зөвлөлтийн их нэвтэрхий толийн II хэвлэлд <<улар>> (ССРЛЯ, XVII-530) гэж орсон болно.

Энэ улар хэмээх нэр одоо ойрад аялгуунд байнга хэрэглэгддэг үг, улмаар баяд зэрэг аман аялгуунд улир гэдэг нэрээр явж байна. Улир гэдэг нь хойлог шувууны өөр нэр. Улмаар <<Улиртын хамар>> гэдэг хад асга, бартаа ихтэй тэр улир шувууны гол нутагладаг газрыг хэлдэг юм. Энэ талаар үгийн гарал судалдаг эрдэмтэд тодруулж ярина гэдэгт найдаж байна.

Монгол хэлний улс гэдэг үгийг улус гэж бичлэгийн хэлбэрээр нь аваад, хот айл, гацаа, суурин, овог төрлөөр нэг доор суурьшсан хүмүүс, монгол, хальмагт улус, кавказад аул гэх зэргээр хэлнэ. Сибирь, Якут нутагт бас хэлнэ. Энэ бол монгол хэлний улус гэдэг үг гэжээ.

17-тын тольд 1. Төв Ази болон Дорнод Европын нутаг дээр монголын хааны эзэмшлийг ингэж нэрлэнэ. 2. Евразийн түрэг, монгол ард түмний суурин, хот айлыг хэлнэ. 3. Якутын хуучин засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж гэж оржээ. Энэ тольд тухайн үгээс улусник, улусный зэрэг үг үүсгэж хэрэглэх болсон байна. Энэ үг анх 1731 онд Вейсманновын тольд улус, 1771 онд Оросын гаралзүйн тольд тэмдэглэгдсэнээс хойш хэрэглэгдэж байна(ССРЛЯ, XVII-554).

МНТ-д ... önggeten ulus ülü temecet... (I. de Rachewiltz, index, §64-1313)

Ууль гэдгийг улюля өрнө, дорно зүгийн уулийн нэр гэжээ.

Ундаа гэдэг үгийг ундак хэмээн бичээд, татарын айран, Сибирь, Якут зэрэг улсын ундаа, устай нийлүүлж бүлсэн иссэн сүү юм гэжээ.

Унь гэдэг үгийг унина гээд, тооно, хана хоёрыг хооронд нь холбох урт мод гэв. Оренбург, Астрахань, Киргиз зэрэг нутагт хэрэглэнэ. Энэ үг хальмаг, буриад хэлнээс орос хэлэнд орсон үг байна.

Монгол хэлний хурай, орос хэлнээс орсон ура гэдэг үгийг уран хэмээн тэмдэглээд, башкир, киргиз, татар цэргийн зоригжуулах дуудлага гэв. Зарим тольд давшилтад цэргийг зоригжуулах дуудлага үг, аялга үг зэргээр тайлбарлав. Орчин цагийн монгол хэлэнд цог жавхлантайг үзүүлэхэд дуудан хашгирах үг болсон байна.

Цаатан нарын орон гэрийн нэр болох урц гэдгийг ураса гээд, якут нарын үүсэн овоохой, урц гэв.

Яргуй цэцгийг ургуй гээд, эрхүү муж, монгол нутгийн цасан дороос ургаж нарч ирдэг цэцгийн нэр гэв.

Монгол хэлний үр, үрэс(гаргах) гэдгийг урень хэмээн бичээд, хасаг, чуваш зэрэг нутагт урень, татарууд айран гэх ба энэ нь устай хольж бүлсэн мсгэсэн ундаа юм. Урeная кадка буюу айргийн хувин гэж хэлнэ.

Хадагийг Байгалын чанадад хэрэглэнэ, энэ нь бэлэг болгон өгөх урт торгон алчуур юм.

1858 онд Оросын Академиас хэвлүүлсэн нутгийн аялгууны тольд тэмдэглэгдсэнээс хойш хэрэглэгдэж байгаа үг. Энд монгол үг гэж тэмдэглэжээ (ССРЛЯ, XVII-7). Энэ нь төвэд хэлний kha btags - торгон алчуур, самбаа (МХГҮТ-196) гэсэн үг юм.

Халзан хэмээх тэмдэг нэрийг орос хэлний тэмдэг нэрийн хэлбэрээр халзаны болгоод халзан, хожгор хэмээн тайлбарлав.

Халтар, халиун зэрэг тэмдэг үгийг мөн орос хэлний тэмдэг нэрийн хэлбэрээр халтарый, халюный гээд, дорнод сибирь, монгол нутагт хар хээр, хүран; цагаан хоншоортой, хонгор халиун, цайвар халиун, хул ч гэх үү? Эдгээр нь морины зүс юм.

Хаан хэмээх үгийг хан гэж бичээд Азийнхны эзэн хаан, зарим түрэг, монгол зэрэг улсад хэмжээгүй эрхэт эзэн: дорнын зарим улс, оронд бас хаан бий.

Жужаны эзэд өөрсдийн давуутай байдлыг илтгэх гэж урьдын <<шаньюй>>, <<хан>> хэмээх цолноос ялгаатай <<каган>> гэдэг шинэ цолыг тувтам хэрэглэх болжээ. Тэр цагаас нааш түрэг, монголын эздийг <<каган>> хэмээн өргөмжлөх заншил үүсчээ. (БНМАУ-ын түүх, нэмэн засварласан хоёрдахь удаагийн хэвлэл, УБ, 1966, хууд. 85-86)

Яновскийн 1806 онд хэвлүүлсэн Шинэ үгний тайлбар тольд хан гэсэн хэлбэрээр оржээ. Энэ нь түрэг хэлний han (ССРЛЯ, ХҮП-26) гэсэн үг юм гэжээ.

Хандгай гэдэг үг хандагай, кандалай хэлбэрээр ороод, хандгайг хэлнэ гэжээ.

Харгана гэдэг үгийг карагана гэж бичээд, өргөстэй жижиг бутлаг ургамал гэж тайлбарласан байна.

Харин хороо хэмээх үгийг хорун гэж бичээд, нохойны хороо гэж тайлбарласан байна.

Худ хэмээх үгийг хода гэж бичээд, Казань, Симбирск зэрэг газар хэлнэ, охины талыг хүргэний тал хода гэж хэлнэ хэмээн тайлбарласан байна.

МНТ-д ... yisügei quda bi ene söni jewüdün jewüdülba... (I. de Rachewiltz, index, §63-1304)

Хот хэмээхийг хотон гэж бичээд, хальмаг нутагт хот айлыг хэлнэ.

Монгол хэлний хир гэдэг үгийг хрида гээд, нутгийн аялгууны үг, Орлов, Курск, Хальмаг зэрэг газар хэлнэ, бохир заваан, хир буртгандаа баригдсан хүн гэсэн үг.

Худаг гэдгийг худук, кудук, кудык, худг... гэж бичээд, ухмал худаг, тал газрын худаг, устай нүх гэсэн үг гэжээ.

Хулан гэдэг үгийг хулан гэж оруулаад, энэ бол хулан гээд, энэ үгийг Пржевальский, П.Козлов нарын номоос авав гэж тэмдэглэсэн байна.

Хурга хэмээх төл малын нэрийг хураган, хурагашек хэмээн бичээд, сибирь нутагт хэлнэ, хальмагт хурхн гэнэ, энэ нь хурга гэсэн үг гэжээ.

Хурал, хуралдаан гэдэг үг бараг бүх орос хэлний толь бичгүүдэд байх ба В.Далийн тольд хальмаг, монгол зэрэг газрын сүм дугана гэсэн байхад, хожуу үеийн толь бичгүүдэд БНМАУ-ын нутгийн засаг захиргааны дээд байгууллагын нэр, 17-ын тольд БНМАУ-ын дээд болон орон нутгийн сонгуулийн байгууллага, 17-ын тольд БНМАУ-ын дээд болон орон нутгийн сонгуулийн байгууллага... хэмээн тус тус тайлбарласан байна. (ССРЛЯ, XVII-527).

Монгол хэлний цулбуур хэмээх үгийг Орос хэлний дөрвөн боть толь бичигт гээд морь малыг уях, хөтлөхөд зориулан хазаараас уясан урт жолоо гэж рлав. 1847 онд Оросын Академийн тольд чөмбур гэдгээр, 1852 онд Академиас ан нутгийн аялгууны тольд чөмбур гэсэн хэлбэрээр тус тус орсон болно. Энэ нь хэлний čumbur (ССРЛЯ, XVII-841) гэдэг үг юм. ~~хөдөх хөдөгч хөдөгч~~ - повод, б. (Ков. 2206)

Орос хэлэнд чемодан гэдэг үг байх ба энэ нь замд авч явах сав гэсэн үг буюу ан гэсэн үг, улмаар перс хэлний Jāmadān гэдэг үг юм. 1731 онд Вейсманновын чемодан, 1771 онд Оросын гаралзүйн тольд чемодан, 1794 онд Академийн тольд ан хэмээн тус тус тэмдэглэгдсэн байна.

В.Далийн тольд яман гэдэг байх ба энэ нь монгол хэлний ямаа гэсэн үг болно.

Монгол хэлний замч гэдэг үгийг ямщик гэж бичээд, мориороо өртөөний алба хүн бүрээс авах албан татвараас чөлөөлөгддөг тариачин хэмээн тайлбарлав. Энэ рэг хэлний jam гэдэг үг гэжээ. XIII-XVIII зууны үеийн Оросын явуулын сийн унаагаа юулж гардаг морин өртөөний газар юм. Энэ үг Срезневскийн тольд 1704 онд гарсан Поликарповын тольд мөн ям хэмээн, харин ямщик гэдэг үг Оросын риус тольд 1771 онд тэмдэглэгдсэн гэв. Уул нь түрэг хэлний jam хэмээх үг юм н тэмдэглэсэн байна.

Монгол хэлний зарлиг хэмээх үгийг В.Далийн тольд ярлык гээд, энэ нь хууч үг татарын хааны бичиг, жуух, үнэмлэх гэсэн үг гэжээ. Энэ нь түрэг хэлний Jarlyq - гэсэн үг гэжээ. Д.Ушаковын тольд монгол-татарын ноёрхолын үед татарын с Оросын вангуудад олгож байсан захирах эрхийн зарлиг бичиг гэжээ. 17-р н 2090-2091-р талуудад ярлык, -а, м. 1. Грамота, письменный указ хана Золотой 2. Устар. Письменное распоряжение о выдаче чего-либо 3. наклейка на ете... 4. Шаблонное прозвище... сэтэр, нэр хаяг зүүх, өгөх г.м. Срезневскийн ярлык; Поликарповын тольд 1704 онд мөн ярлык хэмээн тэмдэглэгдсэн. Энэ бол хэлний jarlyu, jarlyq - приказ, указ гэсэн үг гэв. Зарлиг хэмээх үгийг монгол үсгээр бичихэд зарлиг ч гэж уншиж болно, яарлиг ч гэж уншиж болно. Хэлшинжлэлийн мьёогоор бол омофон ч болно, омограф ч болно. Энэ гтэй адил тайлбарлагдах үг ~~хөдөх~~ - засаг, яасаг зэрэг болно.

Дүгнэлт: Үгсийн ихэнхи нь монгол ярианы хэлнээс, ялангуяа зарим нутгийн наас орос хэлний толь бичгүүдэд орсон байна гэж үзэх талтай юм. Гэхдээ гийг тогтоохдоо монгол бичгийн хэлний дүрмийг харгалзсан нь гарцаагүй. Зарим хэлбэр нэлээд өөрчлөгдсөнийг орос хэлний авиазүй, үгзүйн ерөнхий зарчимтай ж үзэх ёстой болов уу. Монгол хэлэнд орсон харь үгийг ажиглахад ч иймэрхүү ардагийг анхаарах нь зүйтэй. Энд хоршоо үг байгаад ярианы явцад нийлж нэг үг орос хэлэнд хэвшсэн байна. Ийм үзэгдэл орос хэлэнд байгаа талаар эрдэмтэд ан нь бий. Монгол хэлнээс гадаад хэлэнд орсон үгийг судлахдаа хэлбэрийг рахын зэрэгцээ, үгийн утга, тайлбарыг голлон үзвэл илүү үр дүнтэй байж болох х орос хэлний толь бичгүүдэд тэмдэглэгдсэн зарим монгол үгсийн талаар товчхон хэд ийм буюу.

### Использованная литература

- Даль В.И., Толковый словарь живого великорусского языка, 1880-1882 онд хэвлэгдсэн  
2дахь хэвлэлийн эхээс 1955 онд дахин хэвлэсэн тэр эхээс энэ удаа хэвлэв.  
Москва, 1999
- Ушаков Д.Н. Толковый словарь русского языка М., 1935-1940
- Ожегов С.И., Словарь русского языка, Москва, 1953
- Современный словарь русского литературного языка, I-XVII, Москва, 1948-1965
- Словарь русского языка в четырёх томах, Москва, 1999.
- Дамдинсүрэн Ц., Лувсандэндэв А., Орос-монгол толь, Улаанбаатар, 1982.
- Толковый словарь русского языка, под общей редакцией проф. Ушакова Д.Н., Москва, 1939
- Наделяев В.М., Насилов Д.М., Тенищев Р.Р., Щербак Д.М.  
Древне-тюркский словарь, Ленинград, 1969.
- Русско-татарский словарь, под редакцией Ганиева Ф.А., Москва, 1984
- Русско-калмыцкий словарь, под редакцией Ильишкин И., Москва, 1964
- Юдахин К.К. Киргизско-русский словарь, Москва, 1965
- Дамдинсүрэн Ц., Лувсандэндэв А., Орос-Монгол толь, Улаанбаатар, 1982
- Цэвэл Я., Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966
- Luntu, Norjin C. Oyirad nutug un ajalgu nu uges un hurijanguy, Oburmonggol un jeke  
surgaguli yin keblel un horiy a, 1994
- Словарь иностранных слов, Москва, 1988
- Черных П.Я. Историко-этимологический словарь современного русского языка,  
Москва, 2004
- Сүхбаатар О., Монгол хэлний харь үгийн толь, Улаанбаатар, 1990.
- Сэржээ Ж., Монгол хүний нэрийн лавлах толь, Улаанбаатар, 1991.
- Балжинням Н., Монгол хэлний гадаад үгийн толь, Улаанбаатар, 2005 Васюкова И.А.,  
Словарь иностранных слов, М., 1999.
- Чэн Чан-Хао, Дубровский А.Г., Котов А.В., Русско-китайский словарь, Москва, 1953.
- Шанский Н. Н, Иванов В. В. ..., Краткий этимологический словарь русского языка,  
Москва, 1971.
- Xiandai hanyu cídiǎn, Běijīng, 1998.
- Ковалевский Осип, Монгольско-русско-французский словарь, Казань, 1844